

Нуугдмал сүрьеэ, өвчтөний мэдээлэл (2016-09-19)

Урьдчилан сэргийлэх эмчилгээ өгөх нь

Халдвар хамгааллын эмч нарын мэдээллийн хуудас.

Яаж халдвар авдаг вэ?

Сүрьеэний бактери нэг хүнээс нөгөө хүн рүү агаараар дамжина. Энэ нь өвчтэй буюу халдвартай хүн ханиалгахад ойр орчмын хүн бактериар нь амьсгалах үед тохиолдоно гэсэн үг.

Нуугдмал сүрьеэ гэж юу вэ?

Халдвар авсан хүн бүр сүрьеэгээр өвчлөхгүй. Ихэнх хүмүүсийн хувьд биеийн дархлаа нь бактерийн өсөлтийг зогсоох чадвартай. Бактери нь биед байгаа ч идэвхгүй гэсэн үг юм. Энэ байдлыг **нуугдмал сүрьеэ** гэдэг.

Нуугдмал сүрьеэ өвчин биш

Та цусны (IGRA) тест эсвэл арьсны (туберкулин) сорил хийлгэсний дараа нуугдмал сүрьеэтэй гэсэн хариу авсан бол та **бүрэн эрүүл** бөгөөд бусдад бактери халдаах эрсдэлгүй гэсэн үг юм. Сүүлд хэзээ нэгэн цагт сүрьеэгийн өвчин үүсэх эрсдэл бий ч, тэр нь жижиг эрсдэл. Тиймд ихэнх тохиолдолд нуугдмал сүрьеэтэй хүнд эмчилгээ хийх шаардлагагүй байдаг.

Урьдчилан сэргийлэх эмчилгээ зарим тохиолдолд өгдөг

Сүүлд хэзээ нэгэн цагт өвчлөх өндөр эрсдэлтэй зарим хүнд урьдчилан сэргийлэх эмчилгээг санал болгодог. Энэ нь эхний ээлжинд хүүхэд өсвөр насныхан, жирэмсэн эсвэл төрсөн хүн, мөн хорт хавдар эсвэл чихрийн шижинтэй (инсулинаар эмчилдэг) эсвэл хүнд бөөрний өвчний шалтгаанаар дархлаа султай хүнд хамаатай. Урьдчилан сэргийлэх эмчилгээг заримдаа саяхан сүрьеэгийн халдварт өртсөн хүнд өгдөг.

Танд урьдчилан сэргийлэх эмчилгээ санал болгож байна

Та нуугдмал сүрьеэтэй бөгөөд та дээр дурдсан бүлгийн аль нэгэнд хамаарах тул танд урьдчилан сэргийлэх зорилгоор эмчилгээ санал болгож байна. Энэ нь та ирээдүйд сүрьеэгээр өвчлөх эрсдэлийг багасгах зорилгоор ингэж байна гэсэн үг юм.